



www.bogdbank.com

2023 ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН

“БОГД БАНК” ХК-ИЙН 2023 ОНЫ II УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“БОГД БАНК” ХК 2023 оны 2-р улирлын байдлаарх санхүүгийн аудитлагдаагүй тайлан болон хагас жилийн хугацаанд шинээр хэрэгжүүлж, нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ болон цаг үеийн ач холбогдолтой ажлуудаас онцлон нийт хувьцаа эзэмшигчдэдээ болон харилцагч нартаа зориулан тоймлон олон нийтэд нээлттэй танилцуулж байна.



ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ:



1. Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсэн.



2. Урьдчилсан хүүг олгодог хугацаагүй хадгаламжийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн.



3. Байгууллагын харилцагчдадаа зориулж, байгууллагын утасны дугаараа дансны дугаараар сонгох үйлчилгээг нэвтрүүлсэн.



ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ:



4. Ноолуур бэлтгэлд зориулан олгох төслийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсэн.



5. Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих төслийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсэн.



6. Хүнсний болон Хөдөө Аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын төслийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсэн.



ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ:



7. Орон нутагт орон сууц авах иргэдэд зориулсан ипотекийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсэн.



8. “Дурсамж түгээнэ” урт хугацааны хадгаламжийн урамшуулалт аяныг нийт харилцагч нартаа зарлав.



ХАМТЫН АЖИЛЛАГАА:



“Азийн хөгжлийн банк”-ны төслийн эх үүсвэртэй батлан даалттай бүтээгдэхүүнийг харилцагчдад хүргэх хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлэв.



“Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим”-тай хамтран Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний салбарыг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох зорилготой санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлэв.



АНУ, Монголын бизнес, хөрөнгө оруулалтын гүүр болдог Монгол дахь Америкийн худалдааны танхимын (АмЧам) гишүүнээр элсэв. Ингэснээр дэлхийн санхүүгийн зах зээл дэх мэдээ, мэдээллийг шуурхай хүлээн авах, өөрийн банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх, улмаар харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүх төрлийн төсөл хөтөлбөрт хамрагдан өргөн хүрээнд олгох боломж бүрдүүлэв.



ХАМТЫН АЖИЛЛАГАА:



БНСУ-ын төлбөрийн картын үйлчилгээ эрхлэгч анхны компаниудын нэг “БиСи карт” байгууллагатай хамтран БНСУ дахь АТМ-ээр дамжуулан Монгол дахь данс руу чөлөөтэй орлого зарлага хийх, харилцан төлбөр хүлээн авах болон нийт 3.3 сая пос машинаар дотоодын төгрөгийн картаар гүйлгээ хийх боломжтой үйлчилгээний эхлэлийг тавилаа.



Хувьцаа эзэмшигчиддээ зориулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж, ногдол ашгийг тараав.



АРГА ХЭМЖЭЭ:



x

Цойлогсог

update 2023

2023.06.24-25

Үндэсний соёл амралтын хүрээлэн

“БОГД БАНК” ХК - ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

Богд банк нь эх дэлхийдээ ээлтэй, нийгэмдээ эерэг, залуусын амьдрах хэв маягт шинэчлэлтэд хувь нэмрээ оруулах зорилгын хүрээнд “UPDATE FESTIVAL 2023” ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Уг арга хэмжээ нь дэлхийн дунджаас 176 дахин бага нүүрсхүчлийн хийг ялгаруулсан анхны арга хэмжээ мөн 15,000 залуусын нэгтгэж чадсанаараа онцлог юм.

АРГА ХЭМЖЭЭ:

- ❑ Монголын ширээний теннисний холбоотой хамтран эх орондоо анх удаа 18 орны 400 гаруй ахмад тамирчдын ширээний теннисний **"Ази тивийн аварга"** шалгаруулах тэмцээнийг зохион байгуулав.
- ❑ Тулааны урлагаар тэсвэр, хатуужил, хүмүүжил олгох таеквондог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан улсын аварга шалгаруулах тэмцээн жил бүр уламжлал болгон ивээн тэтгэж хамтран ажиллаж байна.



САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 2023 оны хагас жилийн байдлаар **130.5 тэрбум төгрөгт** хүрснээр өнгөрсөн 8 жилийн хугацаанд өөрийн хөрөнгөө **7.8 дахин өсгөж**, жилд дунджаар **32 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

НИЙТ ХӨРӨНГӨ

- 2023 оны 2-р улиралд өнгөрсөн жилийн мөн үеэс **50%-иар өсөж 588.78 тэрбум төгрөгт** хүрлээ. 2014 онд байгуулагдсан цагаасаа хойш нийт хөрөнгө **35 дахин өссөн** бөгөөд жил бүр дунджаар **45 хувийн өсөлт** үзүүлсэн байна.

ЦЭВЭР АШИГ

- 2023 оны хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс **88%-аар өсөж 15.13 тэрбум төгрөгт** хүрсэн байна. 2023 оны эцсийн зорилтот түвшин болох **29 тэрбум төгрөгийн ашгийн 52%-ийн гүйцэтгэлтэй** байна.



БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)

№	Балансын зүйл	Balance sheet	2023.06.30
1	ХӨРӨНГӨ	ASSETS	
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	Cash and cash equivalents	97,478,214.4
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	Deposits and placements in banks and financial institutions	44,897,971.8
1.3	Хөрөнгө оруулалт	Financial investments	132,992,668.6
1.3.1	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	Investments in subsidiaries, associates and jointly controlled entities	0.0
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	Loans (net)	280,372,571.3
1.4.1	Хэвийн зээл	High grade	228,691,290.0
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	Standard	39,623,007.8
1.4.3	Чанаргүй зээл	Non-performing loan	10,673,075.0
1.4.4	Зээлийн хойшлогдсон төлбөр	Deferred loan payment	0.0
1.4.5	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	Accrued interest receivable on loans	4,629,374.6
1.4.6	Зээлийн эрсдэлийн сан	Provision for loan losses	(3,244,176.14)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	Derivatives financial assets	1,442,408.3
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	Other financial assets	2,435,202.0
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	Other non-financial assets	9,143,261.0
1.8	Үндсэн хөрөнгө	Fixed assets	7,488,854.7
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Investment property	0.0
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	Assets held for sale	11,625,047.7
1.11	Биет бус хөрөнгө	Intangible assets	911,859.8

БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)

№	Балансын зүйл	Balance sheet	2023.06.30
	Нийт хөрөнгийн дүн	Total assets	588,787,879.7
2	ӨР ТӨЛБӨР	LIABILITY	
2.1	Харилцах, хадгаламж	Current accounts & Deposits	206,973,007.7
2.2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	Due to banks and financial institutions	180,540,073.1
2.3	Бусад эх үүсвэр	Other funding	64,593,244.7
2.4	Дериватив санхүүгийн өр төлбөр	Derivative financial liabilities	223,101.9
2.5	Бусад санхүүгийн өр төлбөр	Other financial liabilities	3,284,498.5
2.6	Бусад санхүүгийн бус өр төлбөр	Other non-financial liabilities	2,673,343.4
	Нийт хөрөнгийн дүн	Total assets	458,287,269.3
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	EQUITY	
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Share capital	100,000,000.0
3.2	Нэмж төлөгдсөн капитал	Share premium	(1,443,177.67)
3.3	Халаасны хувьцаа	Treasury shares	0.0
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	Revaluation surplus	0.0
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Retained earnings	31,992,706.22
3.6	Бусад өөрийн хөрөнгө	Other equity	(48,918.12)
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	Total equity	130,500,610.4
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	Total liabilities and equity	588,787,879.7
	Тэнцлийн гадуурх данс	Off-balance sheet	
	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	Contingent liabilities and commitments	21,232,003.0

БОГД БАНК ХК-ИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мянган төгрөг)

№	Орлого, зардлын зүйл	Income and expenses	2023.06.30
1	Хүүгийн орлого	Interest income	34,942,063.0
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	Deposit with the Bank of Mongolia	104,767.1
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	Deposits and placements in banks and financial institutions	629,549.5
1.3	Үнэт цаасны	Securities	8,549,718.8
1.4	Зээлийн	Loans	24,571,902.1
1.5	Бусад хүүгийн орлого	Other interest income	1,086,125.5
2	Хүүгийн зардал	Interest expense	14,675,598.0
2.1	Харилцахад төлсөн хүү	Interest paid in current accounts	63,180.5
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	Interest paid in deposit accounts	8,482,679.2
2.3	Зээлийн хүүгийн зардал	Loan interest expense	2,091,542.9
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	Securities interest expense	2,286,816.0
2.5	Бусад хүүгийн зардал	Other interest expense	1,751,379.5
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	Interest income (net) [(1)-(2)]	20,266,465.1
4	Эрсдэлийн сангийн зардал	Provision expense	2,419,749.3
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	Deposits and placements in banks and financial institutions	0.0
4.2	Үнэт цаасны	Securities	0.0
4.3	Зээлийн	Loans	2,419,749.3
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	Net interest income after provision [(3)-(4)]	17,846,715.7

БОГД БАНК ХК-ИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мянган төгрөг)

№	Орлого, зардлын зүйл	Income and expenses	2023.06.30
6	Бусад орлого	Other income	8,985,272.1
6.1	Хүүгийн бус орлого	Non interest income	8,953,697.9
6.1.1	Арилжааны орлого	Trading income	431,279.8
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	Income on foreign currency exchange and revaluation	4,243,736.8
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	Fee and commissions income	1,763,421.3
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	Other non interest income	2,515,259.9
6.2	Бусад орлого, олз	Other income and gains	31,574.2
7	Бусад зардал	Other expense	10,551,293.9
7.1	Хүүгийн бус зардал	Other non interest expense	10,506,965.7
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	Other provision expense	2,198.87
7.1.2	Арилжааны зардал	Trading expense	362,090.1
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	Expense on foreign currency exchange and revaluation	2,504,357.0
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	Fee and commissions expense	630,826.7
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	Non operating other expenses	7,007,493.2
7.2	Бусад зардал, гарз	Other expenses and losses	44,328.2
8	Татварын өмнөх ашиг, алдагдал [(5+6-7)]	Profit before tax (5+6-7)	16,280,693.9
9	Орлогын татварын зардал	Income tax expense	1,155,397.6
10	Татварын дараах ашиг, алдагдал [(8-9)]	Profit after tax	15,125,296.3
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	Discontinued Operations net income, expense	0.0
12	Тайлант хугацааны нийт орлогын дүн [(10+11)]	Net profit for the current year (10+11)	15,125,296.3

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2023.06.30

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	30.54%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	30.54%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	37.94%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нэгж валютаар/	<±15%	-11.42%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нийт/	<±30%	-11.47%



2023.06.30 /сая.төг/

Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь	
1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, бусад	985.52	0.76%
1.2	Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл, бусад	1,049.16	0.81%
1.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, бусад	5,476.56	4.21%
2	Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1	Банкны нийт хувьцаа эзэмшигч	Зээл, бусад	985.52	0.76%
2.2	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл, бусад	2,982.20	2.29%
2.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, бусад	15,075.69	11.65%

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



НИЙТ ХӨРӨНГӨ

/сая.төг/



ХАРИЛЦАГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛ


/сая.төг/



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


НИЙТ ӨР ТӨЛБӨР

/сая.төг/



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ


/сая.төг/



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

ХҮҮНИЙ ОРЛОГО


/сая.төг/



- Хүүний орлого
- 2023 оны хагас жилийн гүйцэтгэл
- 2023 оны зорилтот түвшин

ХҮҮНИЙ ЗАРДАЛ

/сая.төг/




- Хүүний зардал
- 2023 оны хагас жилийн гүйцэтгэл
- 2023 оны зорилтот түвшин

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ


ХҮҮНИЙ БУС ОРЛОГО

/сая.төг/



ЦЭВЭР АШИГ

/сая.төг/



МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ



И-Монголиа-аар дамжуулан харилцагчийн 69 төрлийн лавлагааг харилцагчийн зөвшөөрлөөр авах боломжтой болсон.



Богд банкны аппликейшн шинэ өнгө төрхийн сонголтыг нэвтрүүлсэн.

Богд аппликейшн ашиглаад банктай хийсэн гэрээ, бүхий л баримтаа ашиглах cloud шийдэл нэвтрүүлсэн.

Кредит карт скорингийг автоматжуулан, харилцагч онлайнгаар хүсэлт илгээн захиалга өгөх боломжтой болсон.

2023

2023

1 Cap

2 Cap

3 Cap

4 Cap

5 Cap

6 Cap

Өгөгдлийн сангийн удирдах системийг хүчин чадал нэмэгдүүлэх, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах чиглэлээр томоохон хөрөнгө оруулалт хийж эрх бүхий хамгийн сүүлийн хувилбарт шилжсэн.

Зээлийн скоринг хийх процессыг автоматжуулсан.



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



Олон улсын **Enabling Capital Ltd. (EQ)** байгууллагаас 3 дахь санхүүжилтын олголтыг амжилттай авсан



Туркын **AKTIF BANK**-тай корреспондент харилцаа үүсгэсэн

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ГАЗАР

ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

- Банкны системийн чухал үзүүлэлт буюу Монголбанкнаас тогтоосон төлбөрийн чадварын зохистой харьцаа болох 25 хувийг БОГД банк нь өөрийн Актив, пассивын бодлогын дагуу хамгийн багадаа 32.5 хувь дээр тогтмол давуулан биелүүлж ажиллалаа. Мөн Монголбанкнаас тогтоосон Заавал байлгах нөөцийн хэмжээ болох нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс төгрөгийн 8 хувь, валютын 18 хувийг тайлант хугацааны туршид хэвийн хангаж ажилласан болно.

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

- Богд банк нь дотоод болон гадаадын мөнгөний зах зээлд идэвхтэй оролцдог бөгөөд Актив, пассивын бодлогын хүрээнд эрсдэл бага, хөрвөх чадвар өндөртэй ТБҮЦ, ЗГҮЦ зэрэг хэрэгслүүдэд сул мөнгөн хөрөнгөө байршуулж ажилладаг.

ВАЛЮТ АРИЛЖАА

- Богд Банк нь дотоодын валют арилжааны зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж ажилласан бөгөөд цахим банк болон салбар, тооцооны төвүүдээр дамжуулан харилцагчдын валют арилжааны эрэлт, нийлүүлэлтийг 8 төрлийн валютаар хурдан шуурхай, уян хатан нөхцөлөөр хангаж ажиллалаа.
Түүнчлэн импорт, экспортын бизнес эрхэлдэг дотоодын томоохон харилцагч байгууллагуудаа ханшийн эрсдлээс хамгаалах
- зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болох своп, форвард арилжааны хэлцэл санал болгож, гүйцэтгэж ажиллалаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Богд банкны хүний нөөцийн бодлого нь банкны стратегийн зорилго, зорилтуудыг хангахад хүний нөөцийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулах, банкны ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг зөв зохистой үнэлэн дүгнэх холбогдох арга хэмжээг авах замаар хөдөлмөрийн бүтээмжийг өндөр төвшинд байлгах, банктай хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан тэдгээрийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, сургалт, хөдөлмөрийн аливаа асуудал, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналтын үйл явцыг тодорхой болгон ажиллахад оршино.



НИЙТ АЖИЛТАН
204




БАКАЛАВР
77%



МАГИСТР
14%



ДОКТОР
2%





2023
ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН



www.bogdbank.com